



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/104/СТА-ТШЗ

| | |
|--|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2020 он</p> | <p>Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Ахлах аудитор: П.Мөнхтуяа Утас: 70342716 Цахим хаяг:</p> |
|--|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|--|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

| | |
|--|----|
| Аудитын гэрчилгээ | 3 |
| Аудитын тайлан..... | 5 |
| 2.1. Оршил | 5 |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 5 |
| 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 5 |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 6 |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 6 |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 6 |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 6 |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд | 7 |
| 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга..... | 8 |
| 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн..... | 8 |
| 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 9 |
| 2.13. Шилэн дансны мэдээлэл | 9 |
| 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт | 9 |
| 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл..... | 9 |
| Менежментийн захидал..... | 9 |
| Аудит хийгдсэн санхүүгийн тайлан | 10 |
| 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан..... | 10 |
| 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 12 |
| 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 14 |
| 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 16 |
| 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 17 |
| 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан..... | 24 |



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.02.18 № 58

танай _____ -ны № _____ т

Аудитын гэрчилгээ

АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу аймгийн Татварын хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Аймгийн Татварын хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар аймгийн Татварын хэлтсийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.АНХБАЯР

2.1. Оршил

Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Лхагвасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Татварын хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 15-наас 2020 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны дүгээр сарын 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 1/23 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Татварын хэлтсийн 2019 оны үйл ажиллагааны эрхэм зорилго нь Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ татварын алба, татвар төлөгч шударгаар биелүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Технологийн шинэчлэл, хуулийн таатай орчин бий болгон хөнгөн шуурхай чадварлаг чанартай төрийн үйлчилгээ баялаг бүтээгч, татвар төлөгчдөө үзүүлнэ.
- Татварын хуулийн шинэчлэл хийх
Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Татварын хэлтэс нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Интер актив программ хангамж ашигладаг байна.

Татварын хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Татварын хэлтсийн 2019 оны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 10 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн /жилийн эцсийн/ санхүүгийн тайлангийн материаллаг түвшин-г сонгож, эрсдэлийн түвшинг “их, дунд, бага/” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 329236.3 мянган төгрөгөөс тооцон 6581.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшин-г 669751.6 мянган төгрөгөөр тооцсон нь нийт хөрөнгө, орлогын дүнгээс бага учир нийт зардлыг гүйцэтгэлийн үе шатанд суурь үзүүлэлт болгон сонгосон./

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Татварын хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 101496.6 мянган төгрөгөөр буюу 12.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|----------------|-----------------|----------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 10489.1 | 16332.9 | 5843.8 |
| Үндсэн хөрөнгө | 688288.8 | 783941.6 | 95652.8 |
| Нийт хөрөнгө | 698777.9 | 800274.5 | 101496.6 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 698777.9 | 800274.5 | 101496.6 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 698777.9 | 800274.5 | 101496.6 |

Авлага дансны 162.2 мянган төгрөгийн үлдэгдлийг барагдуулж авлагагүй ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдлийг 5843.8 мянган төгрөгөөр өссөн төсвийн хөрөнгөөр 36282.4, ТЕГ-аас 3798.8 мянган төгрөг буюу нийт 40081.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлсний 33.6 хувийг аж ахуйн материал эзэлж байгаа нь байгууллагын өрөөг засварлан тохижилт хийсэнтэй холбон үзэж байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд 2019 онд худалдаж авсан материалууд нь өөрийн байгууллагад шаардлагатай материал худалдан авч зарцуулсан байна.

Бараа материалын дансанд 2019 оны хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн материал бэлтгээгүй ТЕГ-аас 3798.8 мянган төгрөгийн материалыг шилжүүлэн өгснийг тодруулга тайланд бүртгэн тайлагнажээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 95652.8 мянган төгрөгөөр өссөн нь ТЕГ-аас автомашин болон бусад техник хэрэглэлийн 127416.8 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн өгсөнтэй холбогдуулан үзэж байна.

Хөрөнгө оруулалтаар хөрөнгө бэлтгээгүй, ТЕГ-аас 127416.8 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн орлогод авч үнэ төлбөргүй хүлээн авснаар тайлагнажээ.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө байхгүй, 13465.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Биет бус хөрөнгө өссөн буурсан үзүүлэлт гараагүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлгүй тайлагнасан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 800274.5 мянган төгрөг болж 101496.6 мянган төгрөгөөр өссөн нь ТЕГ-аас автомашин, техник хэрэглэл, бусад материал шилжүүлэн өгсөнийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэн авч тайлагнасантай холбон үзэж байна. Энэ нь шаардлагатай хөрөнгө, материалаар ханган ажилласан нь тухайн

байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдах ажлын үр дүн нэмэгдэнэ гэж тайлбарлаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулгын бичил хийгдээгүй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Татварын хэлтсийн тайлант 2019 онд өөрийн орлогыг төлөвлөөгүй болно.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|-----------------|------------|-----------|-------|------|
| | | | | |
| Нийт дүн | | | | |

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт үйл ажиллагаанд зориулан 639394.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 26025.4 мянган төгрөгийг урсгал зардалд, 613368.6 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 639394.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан товч тайлбарлах. /материаллаг дүнтэй хэлбэлзэл бүхий орлогын нэр төрөл, шалтгаан/

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан товч тайлбарлах. /материаллаг дүнтэй хэлбэлзэл бүхий зардлын нэр төрөл, шалтгаан/

Байгууллагын үйл ажиллагаа боон төсөл, арга хэмжээнд 639394.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 638785.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 638785.1 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь батлагдсан төсвийн дагуу зардлыг зарцуулж цалин болон бусад зардлын 306.6 мянган төгрөгийн хэмнэлт мөн үнэт цаасны орлогын 301.8 буюу нийт 608.4 мянган төгрөгийг төсвийн тухай хуулийн дагуу төсөвт төвлөрүүлэн ажиллажээ.

Нэмэлт төсөв: Засгийн газрын нөөц сан-гаас 9000.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 301.8 мянга, нийт 9301.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Дээрх орлогыг татварын өдрийг тохиолдуулан сургалтын материалд 9301.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 10 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 10 эрсдэл тодорхойлж эрсдэлийн үнэлгээний дүнд нийт 8 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 6836.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байхаар 3 зөвлөмж өглөө.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Томилолтын зардлыг анан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллах, хөрөнгийн тушаалыг гаргахдаа аль эх үүсвэрээс гаргах хэнд хариуцуулах тухайгаа тодорхой бичиж тушаал гаргах ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь мэдээлж ажилласныг нийцлийн аудитаар авч үзэх болно.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5750.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж хүргүүлэн ажилласнаас зөвлөмжийн хэрэгжилтийг 85 хувьтай гэж үзэж байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Татварын хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.Зардал

Илрүүлэлт: Байгууллагын даргын "ажилчдыг шагнах" тухай тушаалыг үндэслэн 12 ажилчдыг 6410.0 мянган төгрөгөөр шагнасан боловч цалингийн зардлаас зарцуулж шагнасан. Шагналын тушаалд аль эх үүсвэрээр зардал гаргаж хэнд хариуцуулах тухай шийдвэр гаргаж тушаал гаргаагүй зөрчил илэрлээ.

1.1 Эрсдэл

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа доголдох дотоод хяналт сулрах

1.2 Өгсөн зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6.4.1, НББ-ийн тухай хуулийн 13.6 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

1.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийн дагуу ажиллах

2. Зардал

Илрүүлэлт: Томилолтын зардлыг 116.5 мянган төгрөгөөр илүү, дутуу тооцон олгож анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй байна.

2.1 Эрсдэл: Санхүүгийн тайлан мэдээ буруу илэрхийлэгдэх

2.2 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.1, НББ-ийн тухай хуулийн 13.6 дахь заалтыг мөрдлөг болгох.

2.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн дагуу ажиллах

3. Зардал

Илрүүлэлт: Шатахуун зарцуулалтыг анхан шатны баримтад тулгуурлан үнэн бодитоор зарцуулалтыг тайлагнаагүй, даргын цохолт нярвын тайлагнасан шатахууны тайлан 309.7 мянган төгрөгийн зөрүүтэй байна.

3.1 Эрсдэл: Байгууллагын санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.2 Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 13.1, 13.6 дахь заалтыг мөрдөж ажиллах.

3.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн дагуу ажиллах

Мэдэгдэл:

Аудитаар өгсөн 3 зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож 2020 оны 05 сарын 25-ны дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг мэдэгдье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Татварын хэлтэс

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|-------------------------|--------------------|--------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>10489096.15</u> | <u>16332967.50</u> |
| 33 | АВЛАГА | 162246.15 | |

| | | | |
|------------|---|----------------------------|----------------------------|
| 33402 | Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/ | 162246.15 | |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 10326850.00 | 16332967.50 |
| 354 | Хангамжийн материал | 10326850.00 | 16332967.50 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2224030.00 | 2570457.50 |
| 35420 | Аж ахуйн материал | 3734620.00 | 4429000.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | | 325000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 4368200.00 | 9008510.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>688288847.37</u> | <u>783941589.55</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 688288847.37 | 783941589.55 |
| 392 | Биет хөрөнгө | 675368847.37 | 771021589.55 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 654972391.43 | 654972391.43 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | 12770828.05 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 62000000.00 | 177000000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | 57342764.36 | 65882299.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 83107025.50 | 76384430.50 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | 75782436.15 | 70982349.06 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 41993637.50 | 52465570.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | 33579006.55 | 40165326.27 |
| 393 | Биет бус хөрөнгө | 12920000.00 | 12920000.00 |
| 39301 | Программ хангамж | 1030000.00 | 1030000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | 1030000.00 | 1030000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 12920000.00 | 12920000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>698777943.52</u> | <u>800274557.05</u> |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>698777943.52</u> | <u>800274557.05</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 698777943.52 | 800274557.05 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 545902934.52 | 545902934.52 |
| 51101 | Өмч: - төрийн | 545902934.52 | 545902934.52 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -143223902.27 | -43367288.74 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -140708280.67 | -143223902.27 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -2515621.60 | 99856613.53 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 296098911.27 | 297738911.27 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>698777943.52</u> | <u>800274557.05</u> |

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|---------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 592333707.14 | 769588221.25 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 2568583.75 | 121194221.25 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 2568583.75 | 121194221.25 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2253135.00 | 121194221.25 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1187955.00 | 301820.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1065180.00 | 120892401.25 |
| 120009 | Бусад орлого | 315448.75 | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 589765123.39 | 648394000.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 542335100.00 | 639394000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 542335100.00 | 639394000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 47430023.39 | 9000000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 14427000.00 | 9000000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3063262.39 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 29939761.00 | |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 568757909.82 | 669731607.72 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 568757909.82 | 669731607.72 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 563425682.82 | 655201346.95 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 400554046.00 | 435074261.09 |
| 210101 | Үндсэн цалин | 301883562.00 | 299969161.09 |
| 210102 | Нэмэгдэл | 53069188.00 | 78414200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13264400.00 | 15720000.00 |
| 210104 | Урамшуулал | 32336896.00 | 40970900.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 48914006.60 | 54823246.04 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32924264.60 | 38032446.04 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4129379.00 | 4197700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3198872.00 | 3358200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 799715.00 | 839500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7861776.00 | 8395400.00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |

Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|--|--------------------|--------------------|
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 39156824.00 | 39697388.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3298274.00 | 3465412.00 |
| 210302 | Түлш, халаалт | 33950400.00 | 33317300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1908150.00 | 2914676.00 |
| 210304 | Байрны түрээс | | |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | | |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 14447714.00 | 17415837.25 |
| 210401 | Бичиг хэрэг | 4147900.00 | 4019765.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3800000.00 | 6690250.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4973254.00 | 4735952.25 |
| 210404 | Ном, хэвлэл | 1500.00 | 223920.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 765600.00 | 716750.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 759460.00 | 1029200.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6779850.00 | 21187119.00 |
| 210604 | Урсгал засвар | 6779850.00 | 21187119.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5429200.00 | 4988700.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 5429200.00 | 4988700.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 23178695.00 | 43514466.30 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20625420.00 | 41514300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 100000.00 | 216000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 800000.00 | 782910.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 200000.00 | 84200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 95000.00 | 86970.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 76114.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1358275.00 | 753972.30 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24965347.22 | 38500329.27 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3133650.00 | 12261385.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 21831697.22 | 26238944.27 |
| 211101 | Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр | | |
| 211201 | Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр | | |
| 212101 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | | |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | | |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5332227.00 | 14530260.77 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 4064600.00 | 13861620.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | 12361620.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4064600.00 | 1500000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1267627.00 | 668640.77 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1267627.00 | 668640.77 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 23575797.32 | 99856613.53 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 26091418.92 | |

| | | | |
|---|--|---------------------------|---------------------------|
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -26091418.92 | |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>-2515621.60</u> | <u>99856613.53</u> |

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|----------------------------|----------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>557950055.00</u> | <u>648695820.00</u> |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1187955.00 | 301820.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1187955.00 | 301820.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1187955.00 | 301820.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1187955.00 | 301820.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 556762100.00 | 648394000.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 542335100.00 | 639394000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 542335100.00 | 639394000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 14427000.00 | 9000000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 14427000.00 | 9000000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>547530155.00</u> | <u>645537685.00</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 547530155.00 | 645537685.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 542197928.00 | 631007424.23 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 399352450.00 | 435074261.09 |
| 210101 | Үндсэн цалин | 280913850.00 | 299969161.09 |
| 210102 | Нэмэгдэл | 66545700.00 | 78414200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14449500.00 | 15720000.00 |
| 210104 | Урамшуулал | 37443400.00 | 40970900.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 49962400.00 | 54660999.89 |

| | | | |
|-------------|--|--------------------|--------------------|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33030064.00 | 37870199.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4232767.00 | 4197700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3382504.00 | 3358200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 851131.00 | 839500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8465934.00 | 8395400.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 39156824.00 | 39697388.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3298274.00 | 3465412.00 |
| 210302 | Түлш, халаалт | 33950400.00 | 33317300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1908150.00 | 2914676.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 14255054.00 | 17325037.25 |
| 210401 | Бичиг хэрэг | 3307150.00 | 3817465.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3800000.00 | 6690250.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4991254.00 | 4735952.25 |
| 210404 | Ном, хэвлэл | 315000.00 | 223920.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 765600.00 | 716750.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1076050.00 | 1140700.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6900000.00 | 23115959.00 |
| 210604 | Урсгал засвар | 2500000.00 | 23115959.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5429200.00 | 4988700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5429200.00 | 4988700.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 22142000.00 | 42957494.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20947000.00 | 41711300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 100000.00 | 216000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 800000.00 | 782910.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 95000.00 | 84200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 200000.00 | 86970.00 |
| 210807 | Газрын төлбөр | 0.00 | 76114.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5000000.00 | 13187585.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5000000.00 | 13187585.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5332227.00 | 14530260.77 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 4064600.00 | 13861620.00 |

| | | | |
|-------------|--|----------------------------|---------------------------|
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | 12361620.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4064600.00 | 1500000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1267627.00 | 242120.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1267627.00 | 242120.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 0.00 | 426520.77 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 426520.77 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>10419900.00</u> | <u>3158135.00</u> |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 140009 | Бусад хөрөнгө | 10419900.00 | 3158135.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | <u>10419900.00</u> | <u>3158135.00</u> |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | <u>10419900.00</u> | <u>3158135.00</u> |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 10419900.00 | 3158135.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 10419900.00 | 3158135.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>-10419900.00</u> | <u>-3158135.00</u> |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | <u>0.00</u> | <u>0.00</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 0.00 | 0.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 0.00 |

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| C01 | 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 532,982,934.52 | 8,897,393.33 | -140,708,280.67 | 401,172,047.18 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |

| | | | | | |
|-----|--|----------------|----------------|-----------------|----------------|
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 532,982,934.52 | 8,897,393.33 | -140,708,280.67 | 401,172,047.18 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 12,920,000.00 | 287,201,517.94 | | 300,121,517.94 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | -2,515,621.60 | -2,515,621.60 |
| C08 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 545,902,934.52 | 296,098,911.27 | -143,223,902.27 | 698,777,943.52 |
| D01 | 2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 545,902,934.52 | 296,098,911.27 | -143,223,902.27 | 698,777,943.52 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 545,902,934.52 | 296,098,911.27 | -143,223,902.27 | 698,777,943.52 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | 1,640,000.00 | | 1,640,000.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 99,856,613.53 | 99,856,613.53 |
| D09 | 2019 оны 06-р сарын 30-нээрх үлдэгдэл | 545,902,934.52 | 297,738,911.27 | -43,367,288.74 | 800,274,557.05 |

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|-----------------------|--|-----------------------|--------------|-----------------------|--------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 545270700.00 | 545184628.00 | 639394000.00 | 639027179.23 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 545270700.00 | 545184628.00 | 639394000.00 | 639027179.23 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 541206100.00 | 541120028.00 | 625532300.00 | 625165559.23 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 399353800.00 | 399352450.00 | 435340100.00 | 435074261.09 |

Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | | |
|-------------|---|--------------|--------------|--------------|--------------|
| 210101 | Үндсэн цалин | 281115200.00 | 280913850.00 | 300235000.00 | 299969161.09 |
| 210102 | Нэмэгдэл | 66345700.00 | 66545700.00 | 78414200.00 | 78414200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14449500.00 | 14449500.00 | 15720000.00 | 15720000.00 |
| 210104 | Урамшуулал | 37443400.00 | 37443400.00 | 40970900.00 | 40970900.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | | | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 49962400.00 | 49962400.00 | 54661000.00 | 54660999.89 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33594300.00 | 33030064.00 | 37870200.00 | 37870199.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4092000.00 | 4232767.00 | 4197700.00 | 4197700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3273600.00 | 3382504.00 | 3358200.00 | 3358200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 818400.00 | 851131.00 | 839500.00 | 839500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8184100.00 | 8465934.00 | 8395400.00 | 8395400.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 39228600.00 | 39156824.00 | 39776300.00 | 39697388.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3077000.00 | 3298274.00 | 3100000.00 | 3465412.00 |
| 210302 | Түлш, халаалт | 33951100.00 | 33950400.00 | 33491100.00 | 33317300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2200500.00 | 1908150.00 | 3185200.00 | 2914676.00 |
| 210304 | Байрны түрээс | | | | |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 14675100.00 | 14674954.00 | 17575100.00 | 17575037.25 |
| 210401 | Бичиг хэрэг | 3500000.00 | 3307150.00 | 3500000.00 | 3817465.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3800000.00 | 3800000.00 | 6700000.00 | 6690250.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5110000.00 | 4991254.00 | 5110000.00 | 4735952.25 |
| 210404 | Ном, хэвлэл | 500000.00 | 315000.00 | 500000.00 | 223920.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 765100.00 | 765600.00 | 765100.00 | 716750.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1000000.00 | 1495950.00 | 1000000.00 | 1390700.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | | | |
| 2105 | Норматив зардал | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | | | |
| 210502 | Хоол, хүнс | | | | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | | | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9835600.00 | 9829200.00 | 26025400.00 | 26024094.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4400000.00 | 4400000.00 | | |

Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | | |
|-------------|--|-------------|-------------|-------------|-------------|
| 210602 | Тавилга | | | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | | | |
| 210604 | Урсгал засвар | 5435600.00 | 5429200.00 | 26025400.00 | 26024094.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5435600.00 | 5429200.00 | 5000000.00 | 4988700.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 5435600.00 | 5429200.00 | 5000000.00 | 4988700.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 17715000.00 | 17715000.00 | 33966400.00 | 33957494.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | | 32720000.00 | 32711300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 16520000.00 | 16520000.00 | 216000.00 | 216000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 100000.00 | 100000.00 | 783000.00 | 782910.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 800000.00 | 800000.00 | 84200.00 | 84200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 95000.00 | 200000.00 | 87000.00 | 86970.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 200000.00 | 95000.00 | | |
| 210807 | Газрын төлбөр | | | 76200.00 | 76114.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | | | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | | | |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5000000.00 | 5000000.00 | 13188000.00 | 13187585.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | | | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5000000.00 | 5000000.00 | 13188000.00 | 13187585.00 |
| 211 | ХҮҮ | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 2111 | Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 211101 | Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр | | | | |
| 2112 | Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |

Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | | |
|-------------|---|------------|------------|-------------|-------------|
| 211201 | Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр | | | | |
| 212 | ТАТААС | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 2121 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 212101 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | | | | |
| 2122 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | | | | |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4064600.00 | 4064600.00 | 13861700.00 | 13861620.00 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | | | |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | | | |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 4064600.00 | 4064600.00 | 13861700.00 | 13861620.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | | | | |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | | | |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | | 12361700.00 | 12361620.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | | | |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | | | | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | | | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4064600.0 | 4064600.0 | 1500000.00 | 1500000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 220001 | Барилга байгууламж | | | | |
| 221001 | Их засвар | | | | |

| | | | | | |
|-------------|--|------|------|------|------|
| 222001 | Тоног төхөөрөмж | | | | |
| 223001 | Бусад хөрөнгө | | | | |
| 224001 | Стратегийн нөөц хөрөнгө | | | | |
| 2260 | Гадаад эх үүсвэрээр | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 226001 | Гадаад эх үүсвэрээр | | | | |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | | | | |
| 231001 | Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл | | | | |
| 232001 | Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл | | | | |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | | | | |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | | | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | | | |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | | | | |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | | | | |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | | | |
| 1340 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | | | | |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | | | | |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | | | | |

| | | | | | |
|---------------|--|-------|-------|-------|-------|
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | | | | |
| | | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | | | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | | | |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | | | | |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | | | | |
| 122 | ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ | | | | |
| | | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | | | | |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | | | | |
| 14 | БУСАД ЭХ ҮҮСВЭР | | | | |
| | | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 145005 | Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх | | | | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | | |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | | | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | | | | |
| | | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | | | | |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | | | |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | | | | |
| | | 40.00 | 40.00 | 40.00 | 39.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.0 | 1.0 | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 34.0 | 34.0 | 34.00 | 33.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5.0 | 5.0 | 5.00 | 5.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | | | | |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | | | | |
| | | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 630 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД | | | | |
| | | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |

| | | | | | |
|------------|--|------------|------------|------------|------------|
| 630001 | Төрийн өмчит ЕБС | | | | |
| 630002 | Хувийн ЕБС | | | | |
| 631 | СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | | | | |
| 631002 | Хувийн өмчит СӨБ байгууллага | | | | |
| 632 | МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 632001 | Төрийн өмчит МСҮТ | | | | |
| 632002 | Хувийн МСҮТ | | | | |
| 64 | ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 640001 | Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо | | | | |
| 640002 | Улсын эмнэлгийн амбулаториор эмчлүүлэгсдийн тоо | | | | |
| 640003 | Хувийн эмнэлгээр эмчлүүлэгсдийн тоо | | | | |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 650001 | төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | | | | |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | | | | |
| 650003 | Ажлын албаны албан хаагч (АА) | | | | |
| 650004 | СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | | | | |
| 650005 | ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ) | | | | |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | | | | |
| 650007 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | | | | |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | | | | |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | | | | |
| 650010 | Гэрээт ажилтан | | | | |

| | | | | | |
|--------|--------------------------------|--|--|--|--|
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | | | | |
|--------|--------------------------------|--|--|--|--|

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| ҮЗҮҮЛЭЛТ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|-------------------------------|------------|-----------|
| ЗДН-өөс | 9000000 | 9000000 |
| Үндсэн үйл ажиллагааны орлого | | 301820 |